



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-НИЙ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/109/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 260512 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн “Мэдээлэл Аудит” ХХК-ийн
Захирал Д.Товуудорж
Утас: 70159511, 99049511
Цахим хаяг: medeeleaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
4.4. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
7. Аудитын илрүүлэлт	17
7.1 Залруулсан алдаа	17
7.2 Зөвлөмж.....	18
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АХГ	Аудитын хоёрдугаар газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДС	Амгалан дулааны станц
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ДЭХ	Дулааны эрчим хүч
ЗЗМС	Зам засвар машинист станц
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НА	Нотлох ажил
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦДҮС	Цахилгаан түгээх үндэсний сүлжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 04/585
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” хуулийн 2 дугаар хавсралтад заасан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3 хэсэгт “Амгалан дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах зорилгоор тус станцын одоо ажиллаж байгаа хүчин чадлыг 116МВт буюу 100 Гкал/цаг-ийн хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх” ажил тусгагдсаны дагуу техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдан Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр болсон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/18 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 20,801.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 28,224.4 сая төгрөгөөр, алдагдлыг 7,422.6 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/171 дүгээр тушаалаар тайлант онд гаднах агаар олон жилийн дунджаас дулаан байснаас шалтгаалан эхний улиралд үйлдвэрлэн борлуулахаар төлөвлөсөн дулааны хэмжээ багассан тул орлогыг 20.5 сая төгрөгөөр бууруулж, үндсэн түүхий эд материал болох нүүрс, цахилгаан, ус болон шатахуун, сэлбэг хэрэгсэл, зохицуулах үйлчилгээний хөлс нэмэгдсэн зэргээс шалтгаалан нийт зардлыг 1,644.4 сая төгрөгөөр, алдагдлыг 1,968.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгожээ. Гүйцэтгэлээр 21,197.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,762.1 сая төгрөгийн зардал гарган, 7,921.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛС	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	361,569,430.66	74,992,232.77
1.1.2	Дансны авлага	924,311,344.01	838,163,886.56
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	841,718.20	841,718.20
1.1.4	Бусад авлага		4,829,977.04
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,019,065,528.19	1,290,234,172.86
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	208,158,517.36	282,261,425.63
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,513,946,538.42	2,491,323,413.06
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	89,190,179,727.52	71,803,294,474.10
1.2.2	Биет бус хөрөнгө	13,106,424,478.23	13,097,154,079.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	427,907,323.31	513,825,623.69
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	102,724,511,529.06	85,414,274,176.79
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	105,238,458,067.48	87,905,597,589.85
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,862,543,932.98	1,893,395,518.02
2.1.1.2	Цалингийн өглөг	1,015,816.00	1,107,746.00
2.1.1.3	Татварын өр	308,465,744.77	526,259,050.80
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		333,333,333.34
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	115,537,900.58	109,081,061.07
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,287,563,394.33	2,863,176,709.23
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,288,166,169.02	1,729,946,676.34
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,015,034,448.83	906,403,853.24
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,303,200,617.85	2,636,350,529.58
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,590,764,012.18	5,499,527,238.81
2.3	Эздийн өмч		

2.3.1	Өмч: төрийн	109,934,367,286.40	99,598,987,346.37
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,496,116,697.19	2,496,116,697.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-24,788,639,528.29	(32,694,883,292.52)
2.3.10	Хуримтлагдсан ашиг тайлант үеийн		(7,906,243,764.23)
2.3.11	Эздийн өмчийн дүн	100,647,694,055.30	82,406,070,351.04
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	105,238,458,067.48	87,905,597,589.85

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,675,045,620.52	21,004,734,515.20
2	Борлуулалтын өртөг	26,001,206,661.94	25,738,945,281.17
3	Нийт ашиг (алдагдал)	(5,326,161,041.42)	(4,734,210,765.97)
4	Түрээсийн орлого	2,618,000.00	1,732,500.00
5	Хүүний орлого	42,756,995.74	752,767.23
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	291,576,200.51	189,987,463.71
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,849,566,251.28	2,227,484,158.47
11	Санхүүгийн зардал		27,846,575.34
12	Бусад зардал	273,725,520.79	239,644,588.97
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	283,023,549.06	513,592,922.77
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(7,395,525,166.30)	(7,550,306,280.58)
19	Орлогын татварын зардал	300,665,783.27	355,937,483.65
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(7,696,190,949.57)	(7,906,243,764.23)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(7,696,190,949.57)	(7,906,243,764.23)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(17,071,083,290.73)	108,365,250,292.86
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(21,365,287.99)	(21,365,287.99)
3	Залруулсан үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(17,0928448,578.72)	108,343,885,004.87
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,696,190,949.57)	(7,696,190,949.57)
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(24,788,639,528.29)	100,647,694,055.30
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
11	Залруулсан үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(24,788,639,528.29)	100,647,694,055.30
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,906,243,764.23)	(7,906,243,764.23)
14	Өмчид гарсан өөрчлөлт	(10,335,379,940.03)				(10,335,379,940.03)
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,496,116,697.19	13,005,849,600.00	(32,694,883,292.52)	82,406,070,351.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,881,858,244.68	23,407,866,058.94
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	23,706,657,028.00	23,178,498,640.37
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		23,900,584.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	175,201,216.68	205,466,834.57
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,321,123,407.30	23,566,673,535.40
	Ажиллагчдад төлсөн	2,917,302,992.07	3,211,065,622.65
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	954,859,522.34	1,080,896,447.82
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,831,475,835.68	9,246,851,143.92
	Ашиглалтын зардалд төлсөн	5,212,843,418.85	4,981,539,911.94
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	638,672,805.73	2,514,437,921.76
	Хүүний төлбөрт төлсөн		27,846,575.34

	Татварын байгууллагад төлсөн	1,126,980,390.61	937,421,544.57
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	1,638,988,442.02	1,566,614,367.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,560,734,837.38	(158,807,476.46)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	42,756,995.74	752,767.23
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	42,756,995.74	752,767.23
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,286,741,693.89	461,855,822.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,286,741,693.89	442,055,822.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		19,800,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,243,984,698.15)	(461,103,054.77)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	500,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		500,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	166,666,666.66
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		166,666,666.66
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	333,333,333.34
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	316,750,139.23	(286,577,197.89)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,819,291.43	361,569,430.66
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	361,569,430.66	74,992,232.77

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	761.6	785.6	739.5	(46.1)	94.1
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	13.2	13.6	13.2	(0.4)	97.1
	Дулаан түгээлт	мян.Гкал	748.4	772.0	726.2	(45.7)	94.1
2	Нийт орлого	мян.төг	21,012.0	20,781.3	21,197.2	416.0	102.0
	Үүнээс Үйл ажиллагааны орлого	сая.төг	20,675.0	20,631.1	21,004.7	373.6	101.8
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	337.0	150.1	192.5	42.4	128.2
3	Нийт зардал	сая.төг	28,407.5	29,868.8	28,747.5	(1,121.3)	96.2
	Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг	216.4	227.8	224.9	(2.9)	98.7
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	(7,395.5)	(9,087.6)	(7,550.3)	1,537.3	83.1
5	Татварын зардал		300.7	303.1	355.9	52.8	117.4
6	Цэвэр ашиг /алдагдал/	сая.төг	(7,696.2)	(9,390.7)	(7,906.2)	1,484.5	84.2
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	сая.төг				0.0	
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	186.0	186.0	186.0	0.0	100.0
9	Нийт цалингийн сан	сая.төг	3,480.4	3,933.7	3,831.0	(102.7)	97.4
10	Нэг ажилчны нэг сарын дундаж цалин	сая.төг	1.6	1.8	1.7	(0.0)	97.4
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	38.0	38.7	39.6	0.9	102.3
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төгрөг					
13	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.4	1.4	1.4	(0.1)	94.4
14	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	959.9	1,069.0	949.2	(119.9)	88.8
15	Нийт авлага	сая.төг	925.2	0.0	843.8	843.8	
	Үүнээс: Найдваргүй	сая.төг	0.0	0.0	0.0		
16	Нийт өглөг	сая.төг	4,590.8	4,277.9	5,499.5	1,221.7	128.6
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	2,287.6	1,524.6	2,863.2	1,338.6	187.8
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	2,303.2	2,753.3	2,636.4	(116.9)	95.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад түрээсийн орлого, биет бус хөрөнгө, аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 10 дугаар сарын 21-ээс 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Мэдээлэл-Аудит ХХК-ийн багийн ахлагч, ахлах аудитор Д.Товуудорж, аудитор Н.Ганданбаавар, Э.Отгонзаяа, шинжээч Ц.Отгонжаргал, С.Наранцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа хэрэгжүүлэв.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон Мэдээлэл-Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01-08/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн ТУЗ нь тайлант онд 10 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн хязгаарлалттай болон тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 25 тогтоолыг хэлэлцэн баталсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 2 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, 2022 оны зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж зардлыг бууруулах талаар тодорхой асуудлыг хөндсөн 2 зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Дотоод аудитор тайлант онд төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл, хангамж, хүний нөөц, архив бичиг хэрэг, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын чиглэлээр хяналтын 20 төрлийн ажлыг төлөвлөж, 95 хувийн биелэлттэй, тайлант онд нийт 10 албан шаардлага өгч, хэрэгжилтийг нь хянаж, тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй.

Аудитын явцад тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталж, мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхийг нягтлан бодох бүртгэлийн данс тус бүрийн бичилт, үйл ажиллагааных нь онцлогийг харгалзан үзэж харьцуулсан горим сорил хэрэгжүүлэхэд дансны төлөвлөлт, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын тусгайлсан бодлого нь шалгагдагчийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн горим, журам байхгүй, зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны зорилтот түвшний нийт зардал 29,868.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 298.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Амгалан дулааны станц ТӨХК-ийн зорилго нь Улаанбаатар хотын зүүн бүсийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах ажил үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс 30.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 70.0 хувийг Эрчим хүчний яам эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Амгалан дулааны станц ТӨХК нь ЗГ-ын 2015 оны 371 дүгээр тогтоолоор үүсэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн

өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүдийн нэг жилийн нийт цалин, урамшууллыг 74.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тодорхой хугацаанд шатахуун зарцуулалтын сорил, туршилтыг явуулсны үндсэн дээр бодит зарцуулалтад тулгуурлан шатахуун зарцуулалтын үндсэн нормыг шинэчлэн тогтоож, мөрдөж эхэлсэн;
- Аудитын зөвлөмжийн дагуу Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн программ худалдан авч, бүртгэлийн үйл ажиллагаандаа ашигласнаар бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, тооцоолол сайжирч, санхүүгийн тайланг программаар үнэн зөв боловсруулах боломжтой болсон;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр касс, агуулах, өмч хамгаалалтай холбоотой журмыг шинэчлэн боловсруулан, мөрдөж эхэлсэн.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж чиг үүргийн давхардлыг арилгасан боловч орон тоог бууруулаагүй байна.

Амгалан дулааны станц ТӨХК нь ажлын байрны давхардлыг арилгах зорилгоор 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд 77 ажлын байранд шинжилгээ хийж, Гүйцэтгэх захирлаар батлуулсан байна. Ажлын байранд шинжилгээг хийхдээ Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив, Галын аюулгүй байдлын тухай хууль, Эрчим хүчний тоног төхөөрөмжийн байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм болон эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй бусад дүрэм, журмуудыг үндэслэн гаргажээ. 2021 онд ажилтнуудын үндсэн болон тарифт цалинг нэмэгдүүлээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Агуулахын журам
- Кассын үйл ажиллагааны журам
- Эд хөрөнгийн тооллого явуулах журам

- Эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материал үнэ бүхий зүйлийн бүртгэл ашиглалт, хадгалалт хамгаалалтын журам
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулжээ.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Амгалан дулааны станц ТӨХК -ний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/				
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	Б	1	2	3=2-1
1	Мөнгөн хөрөнгө	361,569.43	74,992.23	(286,577)
2	Авлага	925,153.06	843,835.58	(81,317)
3	Урьдчилгаа	208,158.52	282,261.43	74,103
4	Бараа материал	1,019,065.53	1,290,234.17	271,169
5	Үндсэн хөрөнгө	89,190,179.73	71,803,294.47	(17,386,885)
6	Биет бус хөрөнгө	13,106,424.48	13,097,154.08	(9,270)
7	Хойшлогдсон татварын хөрөнгө	427,907.32	513,825.62	85,918
8	Нийт хөрөнгийн дүн	105,238,458.07	87,905,597.59	(17,332,860)
9	Өр төлбөрийн дүн	4,590,764.01	5,499,527.24	908,763
10	Богино хугацаат өглөг	2,287,563.39	2,863,176.71	575,613
11	Урт хугацаат өглөг	2,303,200.62	2,636,350.53	333,150
12	Эздийн өмч	100,647,694.06	82,406,070.35	(18,241,624)
13	Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	105,238,458.07	87,905,597.59	(17,332,860)

Касс дах бэлэн мөнгө 3.7 сая, арилжааны банкны харилцах дансанд 71.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 0.8 сая төгрөг, АТБӨЯХАТ-ын авлага 0.02.сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 843.8 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 81.3 сая төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллагаас авах авлага 23,854.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 23,940.4 сая төгрөгийг барагдуулсантай холбоотой байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 2018 онд үүссэн “УБДС” ТӨХК-аас авах нэмэлт усны 0.4 сая төгрөгийн авлага байна.

Тайлант онд 1,391.6 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 208.2 сая төгрөг байгаа нь нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтын баримт шивэгдээгүй 94.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авснаас хувь тэнцүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж байгаа 52.3 сая төгрөг, 2018-2020 онд хийгдсэн боловч санхүүжилт шийдэгдээгүйгээс одоо болтол хийгдээгүй байгаа үнс хадгалах агуулах, нүүрс буулгах хана, аянгын тросс, алсын зайнаас хянах сакада систем зэргийн зураг төслийг хийлгэсэн 61.9 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд байна. Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл 282.2 сая төгрөг байна. 208.2 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал тооцоо байна.

Урьдчилгаа данснаас тайлант онд нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтын баримт шивэгдэж 1,087.6 сая төгрөг, хувь тэнцүүлсэн падааны тухайн жилийн ногдол 22.6 сая төгрөг, ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж барилга, байгууламжийн капиталжуулалт 117.7 сая төгрөг, тавилга эд хогшилд бүртгэсэн 3.3 сая төгрөг, урсгал

засварын зардал 11.3 сая төгрөг, сургалтын зардал 2.9 сая төгрөг, харилцаа холбооны зардал 1.6 сая төгрөг, аудитын үйлчилгээний хөлс 32.1 сая төгрөг, түлшний зардал 2.9 сая төгрөг, хэвлэл захиалгын зардал 2.6 сая төгрөг, нэрийн зөрүүг залруулсан 32.9 сая төгрөг нийт 1,317.5 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,290.2 сая төгрөг болж 271.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нүүрсний нөөцийн үлдэгдэл өмнөх оноос 5,712.3 тонноор нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 10,982.2 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл, материал хангамж нэмэгдэж, 10,711.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө их засварын капиталжуулалт 147.6 сая, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 663.4 сая, худалдаж авсан 5.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 440 дүгээр тогтоолоор ЦДҮС ТӨХК-д 110/10 кВ дулаан дэд станцын барилга, тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлсэн 12,688.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө балансаас баланст шилжүүлсэн 9.2 сая төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд харилцагч байгууллагад өгөх 1,893.4 сая төгрөг, татварын өглөг 526.2 сая төгрөг, цалингийн өглөг 1.1 сая төгрөг, арилжааны банкны зээлийн үлдэгдэл 333.3 сая төгрөг, бусад богино хугацаат өглөг 109.1 сая төгрөг, нийт 2,863.2 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрт Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны эрчим хүчийг найдвартай хангах болон 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд “Амгалан дулааны станц”-ын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлсэн үндсэн хөрөнгийг засгийн газрын буцалтгүй тусламжаар буюу хойшлогдсон орлогын аргаар бүртгэсэнээс үүссэн 906.4 сая төгрөг, санхүүгийн тайлан, татварын зорилгоор байгуулсан элэгдлийн зөрүүгээс үүссэн 1,729.9 сая төгрөг, нийт 2,636.4 сая төгрөгийн өр байна.

Мөн арилжааны банкнаас авсан зээлийн үлдэгдэл 333.3 сая төгрөг нь Голомт банкнаас сул зогсолт, урсгал засварын үеийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор авсан зээл байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардал, орлогын татварын зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 354.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн түүхий эд материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулалтын өртөг нь худалдсан барааны дансны үнэ буюу өртөг, хуваарилагдаагүй үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал болон аж ахуйн нэгж, үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний онцлогоос хамаарч нэмж хуваарилагдах зардлаас бүрдэнэ гэж тодорхойлсон нь шалгагдагч байгууллагын борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тодорхойлж чадахгүй байна.

НБББББ-т үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг хэрхэн хуваарилж бүртгэх, мөн данс тус бүрийн тусгайлан бүртгэлийн бодлого, зохицуулах журмыг тусгаагүй, баталсан дансны нэгдсэн төлөвлөгөө, зардлын ангиллыг баримталж ажиллаагүй зэрэг зөрчлүүдээс тус байгууллагад мөрдөхөөр баталсан НБББББ нь байгууллагын үйл ажиллагаатай нийцээгүйг харуулж байна.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дулааны эрчим хүч үйлдвэрлэх цехүүдэд ашиглагдаг түүхий эд материал, ажиллагсдын цалин хөлс, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл, засварын зардал, хангамжийн материал гэх мэт үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудыг хуримтлуулан бүртгэсэн байна.

4.4. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК нь үйлдвэрлэл болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/18 дугаар тушаалаар Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 20,801.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 28,224.4 сая төгрөгөөр, 7,422.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 964.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/171 дүгээр тушаалаар нийт орлогыг 20,781.3 сая, нийт зардлыг 29,868.8 сая төгрөгөөр, алдагдлыг 9,390.7 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 21,197.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,762.1 сая төгрөгийн зардал гарган, 7,921.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 21,004.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 415.9 сая төгрөг буюу 2.0 хувиар давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 679 дүгээр “Тарифт өөрчлөлт оруулах” тухай тогтоолоор 12 дугаар сард борлуулсан дулааны эрчим хүчийг 1 Гкал тутамд 9,970 төгрөгөөр буюу 37.0 хувиар нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 28,762.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,106.7 сая төгрөг буюу 3.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаад дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

1. Түгээлтийн төлөвлөгөө 45.7 мянган Гкал тасарснаас үндсэн түүхий эд материал болох нүүрс, ус, цахилгааны зардал болон бусад өртгийг бүрдүүлэгч зардал 1,555.3 сая төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан;
2. Ажилчдын нийгмийн зардал 116.6 сая төгрөг буюу 30.0 хувиар буурсан;
3. Сул зогсолтын үеийн ажиллагсдын цалинг олгоход зориулж авсан зээлийн хүүд төлөвлөгдөөгүй 27.7 сая төгрөг зарцуулсан;
4. Үйл ажиллагааны бусад зардал 537.5 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны зардлыг 24.3 сая төгрөг буюу 43.0 хувиар хэтрүүлэн зарцуулж, ТӨБЗГ-ын 2021 оны 440 дүгээр “Үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” тогтоолоор 513.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 110/10 кВ дулааны дэд станцын барилга, тоног төхөөрөмжийг ЦДҮС ТӨХК-д шилжүүлж, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз бүртгэсэнтэй холбоотой.

Их засварын 7 нэр төрлийн 360.3 сая төгрөгийн ажил, техник зохион байгуулалтын арга хэмжээний 6 нэр төрлийн 246.7 сая төгрөгийн ажил, хөрөнгө оруулалтын 18 нэр төрлийн 462.1 сая төгрөгийн ажлуудыг төлөвлөж, 29 нэр төрлийн 949.2 сая төгрөгийн ажлыг 100.0 хувь гүйцэтгэж, 2 нэр төрлийн ажил хойшлогдож, 88.8 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд нийт алдагдал 7,921.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,469.7 сая төгрөгөөр буурсан нь нийт орлого 415.9 төгрөгөөр давж, нийт зардал 1,106.7 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. 1 Гж дулааны эрчим хүчний борлуулах үнийг ЭХЗХ-оос тогтоохдоо өртөгт суурилж тогтоодоггүй нь алдагдалтай ажиллахад нөлөөлдөг байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 42,988.6 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингаас бусад 5 саяас дээш орлогын 5 гүйлгээ буюу 104.1 сая төгрөг, зарлагын 3 гүйлгээ буюу 60.1 сая төгрөг, нийт 164.9 сая төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “ хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хувьд:

- Шагнал, урамшуулалд 38.8 сая төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”,
- “Нью аженси” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан 99/2021 дугаар www.news.mn сайтаар дамжуулан эрчим хүчний талаарх мэдээ, мэдээллийг түгээх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 5.0 сая төгрөг, “Дүгнэх цэг” нэвтрүүлэгтэй холбоотойгоор МҮОНРТ-д 1.2 сая төгрөг, Зөв зүг студид 2.8 сая төгрөг, нийт 9.0 сая төгрөгийн нэвтрүүлгийн төлбөр төлсөн байгаа нь дээрх тогтоолын 1.7-д хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх”,
- Хурал зохион байгуулахад 2.9 сая төгрөг зарцуулсан байгаа нь дээрх тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

“Наху баян констракшн” ХХК, “Монгол ташуур констракшн” ХХК, УБТЗ ХНН-н ЗЗМС зэрэг байгууллагуудад “Дулааны эрчим хүч түгээх” тусгай зөвшөөрөлгүйгээр дулааны эрчим хүч түгээх үйл ажиллагаа явуулж 15.6 сая төгрөгийн орлого олсон байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д “Хуулийн этгээд дараах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” 12.1.7-д “Дулаан түгээх” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтээр тайлант онд шагнал урамшууллын зардлыг хэмнэж ажиллаагүй, нэвтрүүлэг контент санхүүжүүлсэн, хурал зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулж зардал гаргасан, Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтээр тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан түгээх үйл ажиллагаа эрхэлсэн байгаа нь шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,060.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1,060.0 сая төгрөгийг залруулж ажилласан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 132.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 878.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс акт, албан шаардлага, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	10.0	1	10.0	-	-	100
Албан шаардлага	4	132.5	4	132.5	-	-	100
Зөвлөмж	3	878.3	3	878.3	-	-	100
Нийт дүн	8	1,020.8	8	1,020.8	-	-	100

/сая төгрөг/

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 222.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 156.4 сая төгрөгийн алдааг залруулж, 65.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 65.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 209.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотойгоор 156.4 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа. Үүнд:

- 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр 26.3 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэсэн;
- Зээлийн хүүгийн зардал 27.8 сая төгрөгийн бусад зардлаар бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүү 50.3 сая төгрөгийн гүйлгээг бараа материал, түлш шатахуун худалдан авснаар, татварын байгууллагад төлсөн 1.2 сая төгрөгийг бараа материал худалдан авахад төлснөөр ангилсан;
- Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх дүнгээс 29.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан;
- 2021 оны 4-р сарын 28-ны өдрийн 10/2016 дугаар "Дулаан үйлдвэрлэх" тусгай зөвшөөрөл 16.9 сая төгрөгийг зардлаар бүртгэснийг биет бус хөрөнгөөр бүртгүүлэн, ашигласан хугацааны хорогдлыг тооцуулж залруулан бүртгэсэн;
- Үйл ажиллагааны бусад зардлыг ААНОАТ тайланд татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлаар тайлагнаж татварын зардал болон өглөгийг 4.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Холбогдох анхан шатны баримт бүрдүүлсэн боловч харилцагч байгууллагаар и-баримт шивэгдээгүй 26.5 сая төгрөгийн гүйлгээ байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Программчлагдах логик контроллёртой холбоотой агуулахад байгаа эвдэрсэн ашиглах боломжгүй 5 хөрөнгө болон шинэ нөөцөд байгаа 2 хөрөнгөд нийт 13.1 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэн нь байгууллагын үр дүнг бууруулж, НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн 61"Хөрөнгийн хувьд хэрэглэх элэгдлийн аргыг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийг зарцуулан ашиглах хүлээгдэж буй хэв загварт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бол тэрхүү өөрчлөгдсөн хэв загварыг тусгахын тулд элэгдлийн аргыг өөрчлөх хэрэгтэй" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Ашиглагдахгүй байгаа хөрөнгүүдэд элэгдэл тооцохгүй байх.

3. Түрээсийн орлоготой холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Амгалан дулааны станц ТӨХК нь 2021 оны 9 дүгээр сард 172.86 м2 талбайтай хуучин гараашийг засварлаж цайны газрын зорилгоор түрээслүүлэхдээ өмнөх түрээсийн гэрээнд тусгагдсан 38.5 м2 талбайгаар тооцож, түрээсийн төлбөрийг авч, 3 сарын хугацаанд нэмэгдсэн талбайд ногдох нийт 4.0 сая төгрөгийн түрээсийн орлогыг алдсан байгаа нь ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолоор төрийн өмчийг цайны газрын зориулалтаар түрээслэх 1м2 талбайн хамгийн бага хөлс 0.01 сая төгрөг байна гэж заасныг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Засвар хийж талбайг нэмэгдүүлсэн цайны газрын талбайн хэмжээг ТӨБЗГ-т мэдэгдэж, цайны газартай байгуулсан гуравласан гэрээг шинэчлэн түрээсийн орлогыг нэмэгдүүлэх.

Зардлын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн НА-22210000053 дугаар "Нөхөн ногдуулалтын акт"-аар 20.8 сая төгрөг, "Дулааны эрчим хүч үйлдвэрлэх" тусгай зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд сунгуулаагүйгээс 1.0 сая төгрөг, үнс тээвэрлэдэг том оврын машины төв замын зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй, тээвэр хийсний 0.4 сая

төгрөг, нийт 22.1 сая төгрөгийн торгууль алданги төлсөн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.4.2 “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Дотоод аудитор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулж, санхүүгийн ажилтнууд татвар ногдох орлогоос хасагдах зардал, хасагдахгүй зардлыг зөв ангилж, бүртгэн тайлагнаж, татварын нөхөн ногдуулалтын акт тавигдах алдаа зөрчил гаргахгүй ажиллах.

5. НБББББ

5.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөөгүй ба батлагдсан гэх НБББББ-г мөрдөж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан СТОУС-д нийцүүлэн, мэргэжлийн түвшинд, нэмэлт зардал гаргалгүйгээр НБББББ-г боловсруулж мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Үйл ажиллагааны бусад зардлыг ААНОАТ тайланд татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлаар тайлагнасан.	Залруулсан	1	4,064.3	1	4,064.3								
2	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	2020 оны санхүүгийн аудитын төлбөр 26.2 сая төгрөгийг ББӨ-р бүртгэж, тайлагнасан.	Залруулсан	1	26,280.0	1	26,280.0								
3	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Зээлийн хүүний зардлыг бусад зардлаар тайлагнасан.	Залруулсан	1	27,846.6	1	27,846.6								
4	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүү 50,279.9 мянган төгрөгийн гүйлгээг бараа материал, түлш шатахуун худалдан авсанаар, татварын байгууллагад төлсөн 1,206.9 мянган төгрөгийг бараа материал худалдан авахад төлсөнөөр ангилал буруу тайлагнасан байна.	Залруулсан	1	51,486.8	1	51,486.8								
5	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх дүнгээс 29,805.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	Залруулсан	1	29,805.0	1	29,805.0								
6	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	2021 оны 4-р сарын 28-ны өдрийн 10/2016 дугаар "Дулаан үйлдвэрлэх" тусгай зөвшөөрлийг биет бус хөрөнгөөр бүртгэж аваагүй байна.	Залруулсан	1	16,874.7	1	16,874.7								
7	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	"АДС" ТӨХК нь 2021 оны 9 дүгээр сард хуучин гаражыг засварлаж, 172.86 м2 үйлчилгээний талбайтай цайны газрыг түрээслүүлдээ хуучин 38.5 м2 талбайтай цайны газрын түрээсийн	Засварласан цайны газрын талбайн хэмжээг ТӨБЗГ-т мэдэгдэж, цайны газартай байгуулсан гурвалсан гэрээг	1	4,030.8								1	4,030.8	

			гэрээгээр тохирсон үнээр түрээсийн орлогыг авч байсан	шинэчлэн мөрдөж ажиллах.													
8	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Татварын ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн НА-22210000053 дугаар "Нөхөн ногдуулалтын акт"-н дагуу 20,801.6 мянган төгрөг, "Дулааны эрчим хүч үйлдвэрлэх" тусгай зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд сунгуулаагүйгээс 1,000.0 мянган төгрөг, үнс тээвэрлэдэг том оврын машины төв замын зөвшөөрлын хугацааг сунгуулаагүй тээвэр хийсний 349.8 мянган төгрөг, нийт 22,151.4 мянган төгрөгийн торгууль төлсөн байна.	Үр ашиггүй зардал гарахаас сэргийлж, холбогдох хууль тогтоомжын дагуу үйл ажиллагаагаа явуулж, татварын тооцож тайлагнаж байх	1	22,151.4										1	22,151.4
9	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Программчлагдах логик контроллер-тэй холбоотой 7 хөрөнгөнөөс 5 эвдэрсэн ашиглах боломшгүй агуулахад, 2 нь шинээрээ буюу нөөцөнд байгаа хөрөнгөнд нийт 13,059.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож байгууллагын үр дүнг бууруулсан байна	Дээрх хөрөнгүүдэд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийг тооцож, элэгдлийн аргыг НБББББ-т тусгаж мөрдөж ажиллах.	1	13,059.6										1	13,059.6
10	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Санхүү бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөөгүй байна. Мөрдөхөөр батлагдсан НБББББ-г мөрдөж, хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Байгууллагынхаа үйл ажиллагааны онцлогтой уялдуулан НБББББ-г боловсруулан мөрдөж ажиллах	1	-										1	-
11	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Анхан шатны баримтаар баталгаажсан боловч Цахим төлбөрийн баримтаар /И-баримт/ баталгаажгаагүй 26,467.3 мянган төгрөгийн гүйлгээ байна.	Ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	1	26,467.3										1	26,467.3
			ДҮН		11	222,066.5	6	156,357.3	-	-	-	-	-	-	-	5	65,709.2
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	"АДС" ТӨХК	АХГ-2022/109/Н А-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 орлогын гүйлгээний 104,835.1 мянган төгрөг, зарлагын 3 гүйлгээний 60,134.2 мянган төгрөгийн гүйлгээ нийт 164,969.3 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	164,969.3									1	164,969.3	

2	"АДС" ТӨХК	АХГ- 2022/109/Н А-СТА-ТӨА	"Дулааны эрчим хүч түгээх" үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр "Наху баян констракшн" ХХК, "Монгол ташуур констракшн" ХХК, УБТЗ ХНН-н ЗЗМС зэрэг байгууллагуудад дулааны эрчим хүч түгээх үйл ажиллагаа явуулж орлого олсон. /Хавсралт-2/	Тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулахгүй байх	1	15,568.7					1	15,568.7				
3	"АДС" ТӨХК	АХГ- 2022/109/Н А-СТА-ТӨА	Тайлант онд хурал зохион байгуулахад 2,904.7 мянган төгрөг зарцуулсан байна. "Нью аженси" ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан 99/2021 дугаар www.news.mn сайтаар дамжуулан эрчим хүчний талаарх мэдээ, мэдээллийг түгээх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 4,950.0 мянган төгрөг, "Дүгнэх цэг" нэвтрүүлэгтэй холбоотойгоор МҮОНРТ-н 1,200.0 мянган төгрөг, Зөв зүг студид 2,800.0 мянган төгрөг, нийт 8,950.0 мянган төгрөгийн нэвтрүүлгийн төлбөр төлсөн байна. Тайлант онд шагнал, урамшуулалд 38,815.9 мянган төгрөг зарцуулсан байна.	Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	3	50,670.6					3	50,670.6				
			ДҮН		5	231,208.7	-	-	-	-	5	231,208.7	-	-	-	-
			НИЙТ ДҮН		16	453,275.2	6	156,357.3	-	-	5	231,208.7	-	-	5	65,709.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 434/А0150055
АХГ-2022/109/НА-СА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны эрчим хүч түгээх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр Наху баян констракшн ХХК, Монгол ташуур констракшн ХХК, "Улаанбаатар төмөр зам" зам засварын машинт станц зэрэг байгууллагуудад түгээж, 15,568,742.06 төгрөгийн орлого олсон.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хуулийн этгээд дараах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ", 12.1.7 "Дулаан түгээх" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Хуульд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж орлого олсон зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Удвал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.ТОВУУДОРЖ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.2020 Bichig_Khereg\Alban Shaardlaga 2022.03.15 Audit_2.Gif 10 Docx

001001262



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 435/А0150055
АХГ-2022/109/НН-СТА-10А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад:

- Тайлант онд 38,815,968.00 төгрөгийн шагнал урамшуулалын зардал гаргасан,
- Хурал зохион байгуулахад 2,904,658.00 төгрөг зарцуулсан
- Нью агенси ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан 99/2021 дугаар www.news.mn сайтаар дамжуулан эрчим хүчний талаарх мэдээ, мэдээллийг түгээх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 4,950,000.00 төгрөг, "Дүгнэх цэг" нэвтрүүлэгтэй холбоотойгоор МҮОНРТ-д 1,200,000.00 төгрөг, Зөв зүг студид 2,800,000.00 төгрөг, нийт 8,950,000.00 төгрөгийн нэвтрүүлгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь тус тогтоолын 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.7 "хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.201\Bichig_Khereg\Alban_Shaardлага\2022\0315_Auditin_2_Gazar-132.Docx

001081260

өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Удвал нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

В. М.

Ц. Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.ТОВУУДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 436/А0150055
АХГ-2022/109/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 орлогын гүйлгээний 104,835,119.24 төгрөг, зарлагын 60,134,245.37 төгрөгийн 3 гүйлгээ, нийт 164,969,364.61 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" зэрэг заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Удвал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.ТОВУУДОРЖ



ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing a conclusion.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.